

**“АВТОТЭЭВРИЙН ҮНДЭСНИЙ ТӨВ” ТӨРИЙН ӨМЧИТ ҮЙЛДВЭРИЙН  
ГАЗРЫН ЗАХИРЛЫГ СОНГОН ШАЛГАРУУЛАХ ЗАР**

**Нэг. Сонгон шалгаруулах үндэслэл зорилго:**

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 20 дугаар зүйл 20.2 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2024 оны 10 дугаар сарын 25-ны өдрийн 512 дугаар тогтоолоор баталсан “Төрийн өмчит үйлдвэрийн газрын захирлыг нээлттэй сонгон шалгаруулах түр журам”-ыг тус тус үндэслэн “Автотээврийн үндэсний төв” төрийн өмчит үйлдвэрийн газрын захирлын албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулна.

Үйлдвэрийн газрын стратеги төлөвлөгөө, зорилго зорилтыг хэрэгжүүлж чадах боловсрол, мэдлэг, туршлага, ур чадвар, ёс зүй, сахилга хариуцлагын шаардлага хангах мөн үйлдвэрийн газрыг тогтвортой удирдах иргэнийг олон нийтэд нээлттэй сонгон шалгаруулж, дүгнэлтийг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын хуралд танилцуулан шийдвэрлүүлнэ.

**Хоёр. Нэр дэвшигчид тавигдах шаардлага:**

Зарлагдаж буй сул орон тоонд Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан болон албан тушаалын тодорхойлолтод тусгагдсан албан тушаалын зорилго, зорилт, чиг үүргийг хэрэгжүүлэхэд тавигдах дор дурдсан тусгай шаардлагыг хангасан иргэнийг бүртгэнэ.

Боловсрол	Бакалавр ба түүнээс дээш боловсролын зэрэгтэй.
Мэргэжил	-Эрх зүй /0421016/ -Төрийн удирдлага /0413066/ -Эдийн засаг /0311016/ -Авто инженерчлэл /0716016/ -Авто машины ашиглалт, авто аж ахуй /0716026/ -Машины электрон систем /0716036/ -Авто хөдөлгүүрийн механик инженерчлэл /0716046/ -Бизнесийн удирдлага /0413016/
Мэргэшил	Төр, бизнесийн удирдлага, автотээврийн чиглэлээр мэргэшсэн байх.
Туршлага	Удирдах ажлыг 5-аас доошгүй жил хийсэн, удирдан зохион байгуулах чадвартай, тухайн салбарт 7-оос доошгүй жил ажилласан.
Ур чадвар	Удирдан зохион байгуулах Дүн шинжилгээ хийх Асуудал шийдвэрлэх Манлайлах Багаар ажиллах

**Гурав. Бүрдүүлэх материал:**

1. Төрийн албан хаагчийн анкет
2. Боловсролын түвшинг тодорхойлсон баримт бичиг /диплом/, хэрэв гадаад улсад их, дээд, сургууль төгссөн бол боловсролын баримт бичгийн баталгаат орчуулга болон бусад сургалт, семинарт хамрагдсан гэрчилгээ, сертификатын хуулбар.
3. Иргэний үнэмлэхийн хуулбар.
4. Ажил байдлын тодорхойлолт /одоо ажиллаж байгаа болон өмнө нь ажиллаж байсан газрын тодорхойлолт/
5. Нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн талаарх тодорхойлолт /e-Mongolia-с татан авах/
6. Иргэний эрүүгийн хариуцлага хүлээж байсан эсэх тухай тодорхойлолт /e-Mongolia-с татан авах/

7. Тухайн албан тушаалд томилогдох хүсэлт, өөрийн мэдлэг, ур чадвараа илэрхийлсэн өргөдөл /гарын үсгээр баталгаажсан байх/.
8. Нэр дэвшигчийн зүгээс эссэ бичиж ирүүлэх. Үүнд:
  - 8.1 Үйлдвэрийн газрын захирлын үүрэгт ажилд томилогдсоноор салбарт гарах ахиц дэвшил болон байгууллагыг урт, дунд хугацаанд хөгжүүлэх чиглэлээр дэвшүүлсэн зорилго, зорилтыг тодорхой тусгасан байна.
  - 8.2 Эссэг бичихдээ нээлттэй эх үүсвэрээс хийсэн судалгаанд түшиглэн, статистик тоо баримт дурдан хүрэх үр дүнг тодорхойлсон байна.
  - 8.3 Эссэ нь нийт 2,500-3,000 үгтэй байна.
  - 8.4 Эссэ нь сонгон шалгаруулалтад нэр дэвшигчийн бүрдүүлэх материалын бүрдэлд багтсан байх тул заавал бичиж ирүүлнэ.

Нэмэлт: Компанийн засаглалын гэрчилгээтэй бол давуу тал болно.

**Дөрөв. Сонгон шалгаруулах үе шат:**

1. Баримт бичгийн бүрдэл.
2. Сорилын шалгалт.
3. Ярилцлага.
4. Сонгон шалгаруулалтын дүнг гаргах.

**Тав. Сонгон шалгаруулалтын материал хүлээн авах хугацаа, хэлбэр:**

Сонгон шалгаруулалтад оролцох иргэний материалыг 2026 оны 05 дугаар сарын 22-ны өдрөөс 06 дугаар сарын 02-ны өдрийн 17:00 цаг хүртэл Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, Засгийн газрын 9-р байр, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 217 тоот өрөөнд хүлээн авна.

**Анхаарах зүйлс:**

- Материалыг битүүмжлэн ирүүлсэн байх.
- Сонгон шалгаруулалтад оролцох хүсэлт ирүүлсэн иргэдийн материалын бүрдэл дутуу тохиолдолд сонгон шалгаруулалтаас хасна.
- Хугацаа хоцорсон материалыг хүлээн авахгүй.
- Сонгон шалгаруулалтад ирүүлсэн материалыг буцаан олгохгүй болно.
- Ирүүлсэн материалаас шаардлагатай тохиолдолд нэмэлт тодруулга авч болно.
- Ирүүлсэн материалтай танилцан, зөвхөн сонгон шалгаруулалтын шаардлага хангасан нэр дэвшигчдээс сорилын шалгалт авч, зөвхөн тэнцсэн иргэнтэй холбоо барьж ярилцлагад урина.
- Нэмэлт мэдээллийг 51-267030 дугаарын утаснаас авна уу.

АЖЛЫН ХЭСЭГ  
2026 ОН